



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

Газрын тосны бүртгэл, тооцооны маягт,
түүнийг хөтлөх заавар, аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Засгийн газрын 2019 оны 178 дугаар тогтоолын 2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлалыг хавсралт ёсоор баталсугай.

2. Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Анхбаяр/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус үүрэг болгосугай.

3. Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар /М.Баяраа/, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар /Э.Батболд/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Д.СУМЬЯАБАЗАР



Уул уурхай, хунд үйлдвэрийн сайдын оны

2020
A/189.. дугаар тушаалын хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮРТГЭЛ, ТООЦООНЫ МАЯГТ,
ТҮҮНИЙГ ХӨТЛӨХ ЗААВАР, АРГАЧЛАЛ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Газрын тосны бүртгэл, тооцооны маягт, түүнийг хөтлөх заавар, аргачлал /цаашид Маягт, заавар, аргачлал гэх/-ын зорилго нь Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл, тооцооны журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч эсхүл оператор компани газрын тосны бүртгэл, тооцооны маягтын дагуу бүртгэх, тооцох, тайлагнах арга зүйг тодорхойлох, зохицуулахад оршино.

1.2. Энэ Маягт, заавар, аргачлалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж мөрдөнө.

1.3. Гэрээлэгч эсхүл оператор компани нь энэ Маягт, заавар, аргачлалын дагуу тайланг гаргаж, бэлтгэсэн ажилтан, хянасан эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулан Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бичгээр болон цахимаар ирүүлнэ. Ирүүлсэн тайланг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий ажилтан гарын үсэг зурж, хүлээн авна.

1.4. Энэ Маягт, заавар, аргачлал нь түүхий тосноос бусад байгалийн хий, уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаанд болон худалдааны хэлэлцээрийн дагуу хийгдсэн борлуулалт, тээврийн гэрээний нөхцөлтэй нийцэхгүй тохиолдолд олон улсад хэвшсэн нийтлэг аргачлалаар тооцож, тайлагнахаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч харилцан тохиролцож болно.

1.5. Энэ Маягт, заавар, аргачлалын дагуу тайлагнахад шаардлагатай дэлгэрэнгүй задаргаа тооцоо, бүртгэх хүснэгт, жагсаалтыг гэрээлэгч эсхүл оператор компани өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж, мөрдөж болно.

1.6. Гэрээлэгч эсхүл оператор компанийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаар боловсруулсан дэлгэрэнгүй задаргаа тооцоо, бүртгэх хүснэгт, жагсаалт нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан байвал зохино.

1.7. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Гэрээлэгч эсхүл оператор компанийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаар боловсруулсан дэлгэрэнгүй задаргаа тооцоо, бүртгэх хүснэгт, жагсаалтад санал өгч болох бөгөөд саналыг Гэрээлэгч эсхүл оператор компани бүртгэлийн үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.

1.8. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ Маягт, заавар, аргачлалаас илүү дэлгэрэнгүй задаргаа, тооцоог шаардсан тохиолдолд, гэрээлэгч эсхүл оператор компани нь саадгүйгээр гарган өгнө.

1.9. Гэрээлэгч эсхүл оператор компани нь энэ Маягт, заавар аргачлалын 2-т заасан тайланг тус заавар аргачлалд заасан хугацаанд Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын дагуу бэлтгэж, тайлагнана.

1.10. Тайлан дахь мөнгөн дүнг Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.4, 10.5-т заасны дагуу амдоллараар, бусад нэгж бүхий дүнг газрын тосны борлуулалт, тээврийн гэрээ болон Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас өгсөн зааврын дагуу бэлтгэж, тайлагнана.

Хоёр. Тайлан

2.1. Гэрээлэгч эсхүл оператор компани дараах тайлангуудыг бэлтгэж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

1. Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлан /Маягт 1/
2. Өртөг нөхөгдөх зардлын дэлгэрэнгүй тайлан /Маягт 2/
3. Өртөг нөхөлтийн тайлан /Маягт 3/
4. Ажлын төлөвлөгөө, төсөв /Маягт 4/
5. Ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл /Маягт 5/
6. Эскроу дансны мөнгөн хөрөнгийн тайлан /Маягт 6/
7. Газрын тосны хуваалтын тайлан /Маягт 7/
8. Газрын тосны нэгж үнийн тайлан /Маягт 8/
9. Борлуулалтын зардлын тайлан /Маягт 9/
10. Борлуулсан газрын тосны хэмжилтийн хураангуй тайлан /Маягт 10/
11. Борлуулсан газрын тосны хэмжилт, зардлын дэлгэрэнгүй тайлан /Маягт 11/

2.1.1. Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлан

Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайланг талбай тус бүрээр улирал тутам, тухайн жилийн өссөн дүн болон өмнөх жилүүдийн өссөн дүн дээр нэмэгдүүлсэн дүнгээр “Маягт 1”-ийн дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.1-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А багана: Зардлын ангилал, төрлийн нэр байх ба Өртөг нөхөгдөх зардлын дэлгэрэнгүй тайлан дахь зардлын ангилал, төрөлтэй ижил байна.

Б багана: Мөрийн утга, дүнг тодорхойлох зорилготой мөрийн дугаар,

В багана: Тухайн тайлант жил эхлэхээс өмнөх жилүүдэд хуримтлагдсан зардлын өссөн дүн,

Г, Д, Е, Ж багана: Тухайн улиралд зарцуулсан зардлын дүн,

И багана: Тухайн жилд зарцуулсан зардлын өссөн дүн буюу Г, Д, Е, Ж багана дээрх дүнгүүдийн нийлбэр,

К багана: Нийт хугацааны өссөн дүн буюу В, И багана дээрх дүнгүүдийн нийлбэрийг тус тус бичнэ.

Мөр:

1, 6, 11, 16 дугаар мөр: Өртөг нөхөгдөх зардлын ангиллын нэр,

2-4, 7-9, 12-14, 17-19 дүгээр мөр: Тухайн өртөг нөхөгдөх зардлын төрөл тус бүрийн нэр, дүн үргэлжилсэн байдлаар байх ба зардлын төрөл тус бүрийн хувьд харгалзах баганад тохирсон утга, дүн,

5, 10, 15, 20 дугаар мөр: Тухайн өртөг нөхөгдөх зардлын ангилалд хамаарах зардлын төрлүүдийн нийт дүн буюу харгалзах 2-4, 7-9, 12-14, 17-19 дүгээр мөр дээрх дүнгүүдийн нийлбэр,

21 дүгээр мөр: Зардлын ангиллуудын нийт дүн буюу 5, 10, 15, 20 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэр дүн,

22 дугаар мөр: Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувиар тооцсон захиргааны зардлын дүн буюу 21 дүгээр мөр дээрх дүнг захиргааны зардлын хувиар тооцсон дүн,

23 дугаар мөр: Нийт өртөг нөхөгдөх зардлын дүн буюу 21, 22 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэр,

24 дүгээр мөр: Өртөг нөхөгдөхгүй зардалд тооцогдох гэрээлэгчийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлдөг төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлс тус бүрийн болон захиргааны зардлын дунгээс хэтэрсэн бусад зарцуулсан зардлын дүн,

25 дугаар мөр: Өртөг нөхөгдөхгүй зардлын нийт дүн буюу 24 дүгээр мөр болон түүний үргэлжлэлд бичигдсэн дүнгүүдийн нийлбэр,

26 дугаар мөр: Нийт хөрөнгө оруулалтын дүн буюу 21, 25 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэрийг тус тус бичнэ.

2.1.2. Өртөг нөхөгдөх зардлын дэлгэрэнгүй тайлан

Өртөг нөхөгдөх зардлын дэлгэрэнгүй тайланг талбай тус бүрээр улирал тутам “Маягт 2”-ын дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.1-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А багана: Зардлын ангилал, төрөл болон тэдгээрт хамаарах зардал тус бүрийн нэр жагсаалтаар байх ба ангилал, төрөл нь өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлантай ижил байна.

Б багана: Мөрийн утга, дүнг тодорхойлох зорилготой мөрийн дугаар,

В багана: Тухайн улиралд зарцуулсан зардлын огноо буюу гүйлгээний огноо,

Г, Д, Е, багана: Тухайн улиралд зарцуулсан зардал нэг бүрийн баримт, данс, журнал, ваучэр зэргийн дугаар, код гэх мэт зардлын бүртгэл, баримтыг тодорхойлох кодчилол, дугаарлалтын үзүүлэлтүүд үргэлжилсэн байдлаар,

Ж багана: Тухайн улиралд зарцуулсан зардлын гүйлгээний утга, тайлбар

З багана: Тухайн улиралд зарцуулсан зардал нэг бүрийн дүн болон зардлын ангилал, төрлийн нийт дүнг харгалзах мөрөнд тус тус бичнэ.

Мөр:

1, 8, 15, 22 дугаар мөр: Зардлын ангилал байх ба “З багана”-д тухайн зардлын ангилалд хамаарах зардлуудын нийлбэр,

2, 5, 9, 12, 16, 19, 23, 26 дугаар мөр: Өртөг нөхөгдөх зардлын тухайн ангилалд хамаарах зардлын төрөл үргэлжилсэн байдлаар байх ба “З багана”-д тухайн зардлын төрөлд хамаарах зардлуудын нийлбэр,

3-4, 6-7, 10-11, 13-14, 17-18, 20-21, 24-25, 27-28 дугаар мөр: Тухайн зардлын төрөлд хамаарах зардлын нэр үргэлжилсэн байдлаар байх ба зардал тус бүрийн хувьд харгалзах баганад тохирсон утга, дүн,

29 дүгээр мөр: Нийт өртөг нөхөгдөх зардлын дүн буюу 1, 8, 15, 22 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэрийг тус тус бичнэ.

2.1.3. Өртөг нөхөлтийн тайлан

Өртөг нөхөлтийн тайланг талбай тус бүрээр улирал тутам, тухайн жилийн өссөн дүн болон өмнөх жилүүдийн өссөн дүн дээр нэмэгдүүлсэн дүнгээр “Маягт 3”-ын дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.1-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А багана: Өртөг нөхөгдөх зардал, өртөг нөхөлтийн түвшин, хөрөнгө оруулалттай холбоотой үзүүлэлт,

Б багана: Тухайн тайлант жил эхлэхээс өмнөх жилүүдэд хуримтлагдсан зардлын өссөн дүн,

В, Г, Д, Е багана: Тухайн тайлант улиралд хамаарах дүн,

Ж багана: Тухайн жилийн өссөн дүн буюу В, Г, Д, Е багана дээрх дүнгүүдийн нийлбэр,

З багана: Нийт хугацааны өссөн дүн буюу Б, Ж багана дээрх дүнгүүдийн нийлбэрийг тус тус бичнэ.

Мөр:

1 дүгээр мөр: Өртөг нөхөгдөх зардлын дүн буюу Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлангийн 21 дүгээр мөр дээрх дүн,

2 дугаар мөр: Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувиар тооцсон захиргааны зардлын дүн буюу Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлангийн 22 дугаар мөр дээрх дүн,

3 дугаар мөр: Нийт өртөг нөхөгдөх зардлын дүн буюу 1, 2 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэр байх ба Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлангийн 23 дугаар мөр дээрх дүн,

4 дүгээр мөр: Өртөг газрын тосоор нөхөгдсөн зардлын дүн буюу Газрын тосны хуваалтын тайлангийн 19 дүгээр мөр дээрх дүн,

5 дугаар мөр: Нөхөгдөөгүй үлдсэн өртөг нөхөгдөх зардлын дүн буюу 3 дугаар мөр дээрх дүнгээс 4 дүгээр мөр дээрх дүнг хассан дүн,

6 дугаар мөр: Хувиар илэрхийлсэн өртөг нөхөлтийн түвшин буюу 4 дүгээр мөр дээрх дүнг 3 дугаар мөр дээрх дүнд харьцуулж тооцсон хувь,

7 дугаар мөр: Өртөг нөхөгдөхгүй зардлын дүн буюу Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлангийн 25 дугаар мөр дээрх дүн,

8 дугаар мөр: Нийт хөрөнгө оруулалтын дүн буюу 1, 7 дугаар мөр дээрх дүнгүүдийн нийлбэр байх ба Өртөг нөхөгдөх зардлын хураангуй тайлангийн 26 дугаар мөр дээрх дүн,

9 дүгээр мөр: Гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны орлогын дүн буюу Газрын тосны хуваалтын тайлангийн 20 дугаар мөр дээрх дүн,

10 дугаар мөр: Гэрээлэгчийн ашиг, алдагдал буюу 4, 9 дүгээр мөр дээрх дүнгүүдийн нийлбэрээс 8 дугаар мөр дээрх дүнг хассан дүнг тус тус бичнэ.

2.1.4. Ажлын төлөвлөгөө, төсөв

Ажлын төлөвлөгөө, төсвийг Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 7.1, 7.3-д заасныг баримтлан “Маягт 4”-ийн дагуу боловсруулж, батлуулна.

Багана:

А багана: Зардлын ангилал, төрөл, дэд төрлийн нэр байх ба Өртөг нөхөгдөх зардлын ангилал нь газрын тосны тухай хуулийн 4.1.27, 4.1.28, 4.1.29, 4.1.30-д заасан зардлын ангилалтай ижил байна.

Б, В багана: Зардлын ангилал, төрөл, дэд төрөл тус бүрээр хэмжих нэгж, ажлын тоо хэмжээ,

Г багана: Зардлын ангилал, төрөл, дэд төрөл тус бүрээр ажлын нэгжийн үнийг ам. доллараар, / тухайн ажлын зардлыг нэгжийн үнээр төлөвлөх боломжгүй бол нийт үнийн дүнгээр төсөвлөж, Б,В,Г баганад бичилт хийхгүй./

Д багана: Зардлын ангилал, төрөл, дэд төрөл тус бүрээр төсвийн нийт дүн буюу В багана Г баганын үржвэр дүнг ам. доллараар тус тус бичнэ.

Мөр:

- 1 дүгээр мөр: Газрын тосны тухай хуулийн 4.1.8 –д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг харгалзах баганын үзүүлэлтээр,
- 2 дугаар мөр: Газрын тосны тухай хуулийн 4.1.17 –д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг харгалзах баганын үзүүлэлтээр,
- 3 дугаар мөр: Газрын тосны тухай хуулийн 4.1.29 –д заасан зардлыг харгалзах баганын үзүүлэлтээр,
- 4 дүгээр мөр: Газрын тосны тухай хуулийн 4.1.30 –д заасан зардлыг харгалзах баганын үзүүлэлтээр,
- 5 дугаар мөр: 1,2,3,4 дүгээр мөрийн дүнгийн нийлбэр дүн ам.доллараар,
- 6 дугаар мөр: Захиргааны зардлын дүн буюу 5 дугаар мөрийн дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувиар тооцсон дүн ам.доллараар,
- 7 дугаар мөр: Өртөг нөхөгдөх зардлын нийт дүн буюу 5 ба 6 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүн ам.доллараар,
- 8 дугаар мөр: Өртөг нөхөгдөхгүй зардлын нийт дүнг ам.доллараар,
- 9 дүгээр мөр: Нийт дүн буюу 7 ба 8 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүн ам.доллараар тус тус бичнэ.

Гэрээлэгч эсхүл оператор компани нь ажлын төлөвлөгөө, төсвийн дэлгэрэнгүй задаргааг нэмэлтээр хавсаргаж болно.

2.1.5. Ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэл

Ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг тухайн жилд хийгдэж дууссан ажлаар болон зарцуулсан зардлаар нь “Маягт 5”-ын дагуу бэлтгэж, өртөг нөхөгдөх зардлын жилийн эцсийн тайлангийн хамт тайлagnана.

Багана:

А, Б, В, Г багана: Батлагдсан ажлын төлөвлөгөө, төсөв байх ба зардлын ангилал, төрөл, тэдгээрт хамаарах ажлын тоо хэмжээ, нэгж үнэ, нийт үнийг,

Д, Е, Ж багана: Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, нэгж үнэ, нийт дүнг,

З, И, К, Л, М багана: Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын үнийн дүн буюу Ж баганын дүнгээс төлбөр нь төлөгдсөн зардлын улирал бүрийн болон өссөн дүнг ам доллараар,

Н багана: Төсөв-гүйцэтгэлийн зөрүү буюу Г багана, М баганын дүнгийн зөрүүг ам. доллараар тус тус бичнэ.

Мөр:

Тайлант жилийн батлагдсан ажлын төлөвлөгөө, төсвийн “Маягт 4”-д тусгагдсан 1-9 дүгээр мөрийн дагуу тайлагнаж, харгалзах баганын үзүүлэлт тус бүрээр гүйцэтгэлийг гаргана.

2.1.6. Эскроу дансны мөнгөн хөрөнгийн тайлан

Эскроу дансны мөнгөн хөрөнгийн тайланг Газрын тосны тухай хуулийн 11.2.9, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 8.2, 8.3-т заасныг баримтлан “Маягт 6”-ын дагуу бэлтгэж, өртөг нөхөгдөх зардлын жилийн эцсийн тайлангийн хамт тайлагнана.

Багана:

А багана: Огноо буюу эскроу дансанд мөнгөн хөрөнгийг байршуулсан он, сар, өдрийг дараалласан байдлаар,

Б багана: Тооцох дүн буюу тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн хайгуулын ажлын хэмжээ, ашиглалтад шилжсэн бол гэрээлэгчид ногдох ашигт тосны хэмжээг ам.доллараар,

В багана: Тооцох хувь буюу газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан хувь хэмжээ,

Г багана: Байршуулах хөрөнгө буюу Б багана дахь дүнгээс В багана дахь хувь хэмжээгээр тооцсон дүнг ам.доллараар,

Д багана: Байршуулсан хөрөнгө буюу эскроу дансанд байршуулсан мөнгөн дүнг ам.доллараар,

Е багана: Тооцох дүн буюу тухайн жилийн хайгуулын ажлын гүйцэтгэлийн хэмжээ, ашиглалтад шилжсэн бол гэрээлэгчид ногдсон ашигт тосны хэмжээг ам.доллараар,

Ж багана: Байршуулах хөрөнгө буюу Е багана дахь дүнгээс В багана дахь хувь хэмжээгээр тооцсон дүнг ам.доллараар,

З багана: Зөрүү буюу Ж багана дахь дүнгээс Д багана дахь дүнг хассан дүнг ам.доллараар тус тус бичнэ. З баганын дүн нь дараагийн жилд байршуулах хөрөнгийн дүнд залруулга хийх дүн байна.

2.1.7. Газрын тосны хуваалтын тайлан

Газрын тосны хуваалтын тайланг талбай тус бүрээр сар бүр “Маягт 7”-ын дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.2-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А багана: Газрын тосны хуваалтын тооцоотой холбоотой үзүүлэлтүүд,

Б багана: Үзүүлэлт тус бүрээр тайлант сарын хуваалтын тооцоонд хамаарах газрын тосны тоо хэмжээ баррелиар,

В багана: Үзүүлэлт тус бүрээр өмнөх саруудын хуваалтын тооцоонд хамрагдсан газрын тосны тоо хэмжээний өссөн дүн баррелиар,

Г багана: Б ба В баганын дүнгийн нийлбэр буюу үзүүлэлт тус бүрээр тайлант жилийн хуваалтын тооцоонд хамаарах газрын тосны тоо хэмжээний өссөн нийт дүн баррелиар,

Д багана: Үзүүлэлт тус бүрээр тайлант сарын хуваалтын тооцоонд хамаарах газрын тосны орлого ам.доллараар,

Е багана: Үзүүлэлт тус бүрээр өмнөх саруудын хуваалтын тооцоонд хамрагдсан газрын тосны орлогын өссөн дүн ам.доллараар,

Ж багана: Д ба Е баганын дүнгийн нийлбэр буюу үзүүлэлт тус бүрээр тайлант жилийн хуваалтын тооцоонд хамаарах газрын тосны орлогын өссөн дүнг ам.доллараар тус тус бичнэ.

Мөр:

1 дүгээр мөр: Борлуулсан газрын тосны тоо хэмжээ баррелиар байх ба тайлант сар, тухайн жилийн өссөн дүн нь Борлуулсан газрын тосны хэмжилтийн хураангуй тайлан “Маягт 10”-ын В багана дахь харгалзах дүнтэй тэнцүү байна.

2 дугаар мөр: Борлуулсан газрын тосны хэмжээнд гарсан өөрчлөлт буюу залруулгын дүн баррелиар,

3 дугаар мөр: 1 дүгээр мөр дэх дүнгээс 2 дугаар мөр дэх дүнг хасах эсхүл нэмэх байдлаар залруулга хийсэн буюу хуваалтын тооцоог хийх газрын тосны тоо хэмжээ баррелиар,

4 дүгээр мөр: Газрын тосны нэгж үнэ байх ба тайлант сарын нэгж үнэ нь Газрын тосны нэгж үнийн тайлан “Маягт 8”-ын “З багана” дахь харгалзах дүнтэй

тэнцүү, тухайн жилийн болон нийт өссөн дүн дэх нэгж үнэ нь хамрах хугацааны дундаж дүн тус тус ам.доллараар,

5 дугаар мөр: Газрын тосны борлуулалтын орлого байх ба харгалзах багана дахь 3 ба 4 дүгээр мөр дэх дүнгийн үржвэр ам.доллараар,

6 дугаар мөр: Нөөц ашигласны төлбөр байх ба харгалзах багана дахь 3 ба 5 дугаар мөр дэх дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон дүн баррелиар болон ам.доллараар,

7 дугаар мөр: Борлуулалтын зардлын тайлан “Маягт 9”-ийн харгалзах баганы 3 дугаар мөр дэх дүнтэй тэнцүү дүн ам.доллараар,

8 дугаар мөр: Үлдэх газрын тос буюу харгалзах багана дахь 5 дугаар мөрийн дүнгээр 6 ба 7 дугаар мөрийн дүнг хассан дүн баррелиар болон ам.доллараар,

9 дүгээр мөр: Өртөгт газрын тосны нийт дүн буюу харгалзах багана дахь 8 дугаар мөрийн дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон дүн баррелиар болон ам.доллараар,

10, 11 дүгээр мөр: Засгийн газар болон гэрээлэгч эсхүл оператор компанид ногдох өртөгт газрын тос буюу харгалзах багана дахь 9 дүгээр мөрийн дүнгээс тухайн жилийн өртөг нөхөгдөх хувь хэмжээгээр тооцсон дүн баррелиар болон ам.доллараар,

12 дугаар мөр: Ашигт газрын тос буюу харгалзах багана дахь 8 дугаар мөрийн дүнгээс 9 дүгээр мөрийн дүнг хассан дүн баррелиар болон ам.доллараар,

13, 14 дүгээр мөр: Засгийн газар болон гэрээлэгч эсхүл оператор компанид ногдох ашигт газрын тос буюу харгалзах багана дахь 12 дугаар мөрийн дүнгээс бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон дүн баррелиар болон ам.доллараар,

15, 16, 17 дугаар мөр: Засгийн газарт ногдох нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тос буюу харгалзах багана дахь 6,10,13 дугаар мөрийн дүнтэй тэнцүү дүн баррелиар болон ам.доллараар,

18 дугаар мөр: Засгийн газарт ногдох газрын тосны нийт буюу харгалзах багана дахь 15, 16, 17 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүн баррелиар болон ам.доллараар,

19, 20 дугаар мөр: Гэрээлэгч эсхүл оператор компанид ногдох өртөгт газрын тос, ашигт газрын тос буюу харгалзах багана дахь 11, 14 дүгээр мөрийн дүнгийн нийлбэр дүн баррелиар болон ам.доллараар,

21 дүгээр мөр: Гэрээлэгч эсхүл оператор компанид ногдох газрын тосны нийт дүн буюу харгалзах багана дахь 19, 20 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүн баррелиар болон ам.доллараар,

22 дугаар мөр: Засгийн газарт ногдох газрын тосны орлогын өмнөх хугацааны төлбөрийн үлдэгдлийг ам.доллараар,

23 дугаар мөр: Засгийн газарт ногдох газрын тосны орлогын тайлант хугацаанд төлөх төлбөрийг ам.доллараар,

24 дүгээр мөр: Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрийн нийт дүн буюу 22 ба 23 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүнг ам.доллараар тус тус бичнэ.

2.1.8. Газрын тосны нэгж үнийн тайлан

Газрын тосны нэгж үнийн тайланг талбай тус бүрээр сар тутам “Маягт 8”-ын дагуу бүртгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.2-т заасан хугацаанд тайлагнана.

Хүснэгт 1. Сарын суурь үнэ (бэнчмарк): Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 5.3.2, 5.3.4-т заасны дагуу тогтоосон тухайн тайлант хуанлийн сарын суурь үнийн талаарх мэдээллийг тайлагнана.

А багана: Суурь үнийн өдөр тутмын мэдээг тухайн тайлант хуанлийн сард нийтэлсэн өдрүүдийн огноо,

Б багана: Суурь үнийн өдөр тутмын мэдээг тухайн тайлант хуанлийн сард нийтэлсэн өдрүүдийн доод үнэ,

В багана: Суурь үнийн өдөр тутмын мэдээг тухайн тайлант хуанлийн сард нийтэлсэн өдрүүдийн дээд үнэ,

Г багана: Суурь үнийн өдөр тутмын мэдээг тухайн тайлант хуанлийн сард нийтэлсэн өдрүүдийн дээд болон доод үнийн дундаж үнэ,

Төгсгөлийн мөр: Харгалзах багана дахь суурь үнийн тухайн тайлант хуанлийн сарын дундаж үнийг тус тус бичнэ.

Хүснэгт 2. Сарын нэгж үнэ: Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 5.3-т заасны дагуу тогтоосон тухайн хуанлийн жилд хамаарах тайлант сарын суурь үнэ, чанараас хамаарсан тохируулга, газрын тосны нэгж үнийн талаарх тооцоог тайлагана.

Д багана: Тухайн хуанлийн жилд хамаарах тайлант сарууд жагсаалтаар,

Е багана: Суурь үнийн тухайн хуанлийн жилд хамаарах тайлант саруудын дундаж үнэ,

Ж багана: Тухайн хуанлийн жилд хамаарах тайлант саруудын дундаж суурь үнэ дээр тооцогдох Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 5.3.6-т заасны дагуу тогтоосон чанараас хамаарсан үнийн тохируулгын дүн,

З багана: Тухайн хуанлийн жилд хамаарах тайлант саруудын газрын тосны нэгж үнийг тус тус бичнэ.

2.1.9. Борлуулалтын зардлын тайлан

Борлуулалтын зардлын тайланг талбай тус бүрээр сар бүр “Маят 9”-ийн дагуу бэлтгэж Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.2-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А,Б багана: Борлуулалтын зардалд хамаарах зардлын ангилал, нэр төрөл, тээврийн компанийн нэр буюу тайлантай холбоотой үзүүлэлтүүд,

В, Г багана: Үзүүлэлт тус бүрээр газрын тосны хэмжих нэгж, тоо хэмжээг,

Д багана: Үзүүлэлт тус бүрээр газрын тосны борлуулалт,тээврийн гэрээнд заасан нэгж үнийг ам.доллараар,

Е багана: Тайлант сарын борлуулалтын зардлын дүн буюу үзүүлэлт тус бүрээр Д ба Г баганын дүнгийн үржвэр ам.доллараар,

Ж багана: Үзүүлэлт тус бүрээр тайлант сарын өмнөх саруудын борлуулалтын зардлын өссөн дүн ам.доллараар,

З багана: Үзүүлэлт тус бүрээр тайлант жилийн нийт өссөн дүн ам.доллараар тус тус бичнэ.

Мөр:

1 дүгээр мөр: Тээврийн зардлыг тээвэрлэгч компани бүрээр,

2 дугаар мөр: Борлуулалттай холбоотой бусад зардлыг борлуулалтын гэрээнд заасан ангилал бүрээр,

3 дугаар мөр: Борлуулалтын нийт зардал буюу 2 ба 3 дугаар мөрийн дүнгийн нийлбэр дүн байх ба Борлуулсан газрын тосны хэмжилтийн дэлгэрэнгүй тайлан “Маят 11”-ийн харгалзах мөр, баганын дүнтэй тэнцүү дүн ам.доллараар,

4 дүгээр мөр: Борлуулсан газрын тос буюу Борлуулсан газрын тосны хэмжилтийн хураангуй тайлан “Маят 10”-ын харгалзах мөр, баганын дүнтэй тэнцүү дүн баррелиар,

5 дугаар мөр: Нэгж баррель газрын тосонд ногдох зардлын дүн буюу 3 дугаар мөрийн дүнг 4 дүгээр мөрийн дунд харьцуулсан дүн ам. доллараар тус тус бичнэ.

2.1.10. Борлуулсан газрын тосны хэмжилтийн хураангуй тайлан

Борлуулсан газрын тосны хэмжилтийн хураангуй тайланг сар бүр “Маят 10”-ийн дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.2-т заасан хугацаанд тайлагнана.

Хүснэгт 1. Борлуулсан газрын тосны хэмжээ:

Багана:

А багана: Тайлант жилийн хуанлийн сар буюу газрын тосыг борлуулсан хугацааг сар бүрээр,

Б багана: Хүлээлгэн өгсөн цэг буюу борлуулсан газрын тосыг хүлээлгэн өгсөн цэгийн нэр бүрээр,

В багана: Борлуулсан газрын тос буюу хүлээлгэн өгсөн газрын тосны хэмжээ баррель /тонн, кг/-аар байх ба борлуулсан газрын тосны хэмжилтийн дэлгэрэнгүй тайлан “Маят 11”-ийн харгалзах мөр, баганын дүнтэй тэнцүү байна.

Г багана: Тээвэрлэсэн шингэн буюу хүлээлгэн өгсөн цэг дэх шингэний хэмжээг баррелиар байх ба борлуулсан газрын тосны хэмжилтийн дэлгэрэнгүй тайлан “Маят 11”-ийн харгалзах мөр, баганын дүнтэй тэнцүү байна.

Д багана: Коэффицент буюу борлуулсан газрын тосны тонн, баррелийн харьцааг тус тус бичнэ.

Хүснэгт 2. Тээвэрлэсэн шингэний хэмжээ (тухайн сарын задаргаа):

Е багана: Тээврийн компани буюу шингэнийг тээвэрлэсэн компанийг нэр тус бүрээр,

Ж багана: Хүлээлгэн өгсөн цэг буюу борлуулсан газрын тосыг хүлээлгэн өгсөн цэгийн нэр бүрээр,

З багана: Тээвэрлэсэн автомашин, вагон цистерний тоо буюу тээвэрлэлт хийсэн компанийн шингэнийг хүлээлгэн өгсөн цэг бүрт автомашин болон вагон цистерний тоогоор,

И багана: Тээвэрлэсэн хэмжээ буюу хүлээлгэн өгсөн цэг бүрт тээвэрлэсэн шингэний хэмжээг тээврийн компани бүрээр, баррель /тонн, кг/-аар тус тус бичнэ.

2.1.11. Борлуулсан газрын тосны хэмжилтийн дэлгэрэнгүй тайлан

Борлуулсан газрын тосны хэмжилтийн дэлгэрэнгүй тайланг сар бүр “Маят 11”-ийн дагуу бэлтгэж, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын 10.2-т заасан хугацаанд тайлагнана.

Багана:

А багана: Тээврийн хэрэгслийн хяналтын хуудасны дугаар,

Б багана: Ачсан шингэний хэмжээг тонноор,

В багана: Ачсан шингэний хэмжээг баррелиар,

Г багана: Ачсан тосны 15°C хэмд шилжүүлэн тооцсон нягт эсвэл API Gravity,
Д багана: Ачсан шингэн дэх ус болон механик хольцын агууламжийн хувь,
Е багана: Ачсан шингэн дэх ус болон механик хольцын хэмжээ тонн /кг/-оор,
Ж, З багана: Ачсан газрын тосны хэмжээ тонн /кг/-оор, баррелиар,
И багана: Ачилт хийсэн он, сар, өдрийг,
К багана: Хүлээлгэн өгсөн цэг дээр буулгасан он, сар, өдрийг,
Л багана: Хүлээлгэн өгсөн цэгийн нэрээр,
М, Н багана: Хүлээлгэн өгсөн шингэний хэмжээ тонноор, баррелиар
О багана: Хүлээлгэн өгсөн газрын тосны 15°C хэмд шилжүүлэн тооцсон нягт эсвэл API Gravity-aар,
Ө багана: Хүлээлгэн өгсөн шингэн дэх ус болон механик хольцын агууламжийг хувиар,
П багана: Хүлээлгэн өгсөн шингэн дэх ус болон механик хольцын хэмжээ тонноор,
Р, С багана: Хүлээлгэн өгсөн газрын тосны хэмжээ тонн/кг/-оор, баррелиар
Т багана: Тээвэр хийсэн компанийн нэрээр,
Ү, Ү багана: Тээвэрлэсэн шингэний хэмжээг тонноор, баррелиар,
Φ, Х, Ц, Ч багана: Тээврийн зардал, борлуулалттай холбоотой бусад зардлыг гэрээний дагуу тооцож ам.доллараар тус тус тайлагнана.

Мөр:

Тээвэрлэлт бүрийг хяналтын хуудасны дугаараар харгалзах баганын үзүүлэлт тус бүрээр бичнэ.

-----oOo-----

Маягт 1**ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХУРААНГҮЙ ТАЙЛАН**

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант ўе:

Тайланг улирал тутам бэлтгэнэ.

(ам.доллар)

Д/д	Зардлын ангилал, төрөл	Мөрийн дугаар	Эхний үлдэгдэл (өссөн дүнгээр)	Тайлант ўе					Эцсийн үлдэгдэл (өссөн дүнгээр)
				1 дүгээр улирал	2 дугаар улирал	3 дугаар улирал	4 дүгээр улирал	Нийт дүн (өссөн дүнгээр)	
	A	B	C	D	E	Ж	И	K	
I	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ								
1	Хайгуулын ажлын зардал	1							
1.1.	[Зардлын төрөл]	2							
1.2.	[Зардлын төрөл]	3							
....	4							
	Дүн (2+3+4+...)	5							
2	Бүтээн байгуулалтын зардал	6							
2.1.	[Зардлын төрөл]	7							
2.2.	[Зардлын төрөл]	8							
....	9							
	Дүн (7+8+9+...)	10							
3	Олборлолтын үйл ажиллагааны зардал	11							
3.1.	[Зардлын төрөл]	12							
3.2.	[Зардлын төрөл]	13							
....	14							
	Дүн (12+13+14+...)	15							
4	Татан буулгалтын зардал	16							
4.1.	[Зардлын төрөл]	17							
4.2.	[Зардлын төрөл]	18							
....	19							
	Дүн (17+18+19+...)	20							
Σ	Нийт дүн (5+10+15+20)	21							
5	Захиргааны зардал ...% (21*...%)	22							
Σ	Нийт өртөг нөхөгдөх зардлын дүн (21+22)	23							
II	ӨРТӨГ НӨХӨГДӨХГҮЙ ЗАРДАЛ								
....	24							
	Дүн (24+...)	25							
Σ	Нийт хөрөнгө оруулалтын дүн (21+25)	26							

Тайлан гаргасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Тайланг хүлээн авсан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 2

ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант ёе:

Тайланг улирал тутам бэлтгэнэ.

(ам.доллар)

Д/д	Зардлын ангилал, төрөл, нэр	Мөрийн дугаар	Гүйлгээний огноо	[Баримт, Данс, Журнал, Ваучерийн дугаар, код, ...]			Гүйлгээний утга	Дүн
				[Дугаар]	[Код]		
	A	Б	В	Г	Д	Е	Ж	З
1	Хайгуулын ажлын зардал	1						(нийт дүн)
1.1.	[Зардлын төрөл]	2						(нийт дүн)
1.1.1.	[Зардлын нэр]	3						
....	4						
1.2.	[Зардлын төрөл]	5						(нийт дүн)
1.2.1.	[Зардлын нэр]	6						
....	7						
2	Бүтээн байгуулалтын зардал	8						(нийт дүн)
2.1.	[Зардлын төрөл]	9						(нийт дүн)
2.1.1.	[Зардлын нэр]	10						
....	11						
2.2.	[Зардлын төрөл]	12						(нийт дүн)
2.2.1.	[Зардлын нэр]	13						
....	14						
3	Олборлолтын үйл ажиллагааны зардал	15						(нийт дүн)
3.1.	[Зардлын төрөл]	16						(нийт дүн)
3.1.1.	[Зардлын нэр]	17						
....	18						
3.2.	[Зардлын төрөл]	19						(нийт дүн)
3.2.1.	[Зардлын нэр]	20						
....	21						
4	Татан буулгалтын зардал	22						
4.1.	[Зардлын төрөл]	23						(нийт дүн)
4.1.1.	[Зардлын нэр]	24						
....	25						
4.2.	[Зардлын төрөл]	26						(нийт дүн)
4.2.1.	[Зардлын нэр]	27						
....	28						
Σ	Нийт дүн	29						(нийт дүн)

Тайлан гаргасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Тайланг хүлээн авсан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 3

ӨРТӨГ НӨХӨЛТИЙН ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант үе:

Тайланг улирал тутам бэлтгэнэ.

(ам.доллар)

Мөр/ Баганы дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (өссөн дүнгээр)	Тайлант үе					Эцсийн үлдэгдэл (өссөн дүнгээр)
			1 дүгээр улирал	2 дугаар улирал	3 дугаар улирал	4 дүгээр улирал	Нийт дүн	
A	B	C	D	E	F	G		Z
1	Өртөг нөхөгдөх зардал							
2	Захиргааны зардал (1*...%)							
3	Нийт өртөг нөхөгдөх зардал (1+2)							
4	Өртөгт газрын тосоор нөхөгдсөн зардал (≤ 3)							
5	Нөхөгдөөгүй үлдсэн өртөг нөхөгдөх зардал (3-4;≥0)							
6	Өртөг нөхөлтийн түвшин (%) (4/100*3)							
7	Өртөг нөхөгдөхгүй зардлын дүн							
8	Нийт хөрөнгө оруулалтын дүн (1+7)							
9	Гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны орлогын дүн							
10	Гэрээлэгчийн ашиг/алдагдал (4+9-8)							

Тайлан гаргасан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Тайланг хүлээн авсан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 4

Батлав:

[Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага]-ын дарга [.....нэр.....]

Огноо:

Батлав:

[Гэрээлэгч] компанийн [албан тушаал]
..... [.....нэр.....]

Огноо:

**"....." ХХК-ИЙН ТАЛБАЙН
..... ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТССӨВ**

Мөрийн дугаар	Зардлын ангилал, төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгжийн үнэ /ам.доллар/	Нийт дүн /ам.доллар/
	A	B	C	D	E
ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ					
1 Хайгуулын ажлын зардал					
1.1.				
1.1.1.				
	Дүн				
1.2.				
1.2.1.				
	Дүн				
	Хайгуулын ажлын зардлын дүн				
2 Бүтээн байгуулалтын зардал					
2.1.				
2.1.1.				
	Дүн				
2.2.				
2.2.1.				
	Дүн				
	Бүтээн байгуулалтын ажлын зардлын дүн				
3 Олборлолтын үйл ажиллагааны зардал					
3.1.				
3.1.1.				
	Дүн				
3.2.				
3.2.1.				
	Дүн				
	Олборлолтын үйл ажиллагааны зардлын дүн				
4 Татан буулгалтын зардал					
4.1.				
4.1.1.				
	Дүн				
4.2.				
4.2.1.				
	Дүн				
	Татан буулгалтын зардлын дүн				
5 Нийт дүн (1+2+3+4)					
6 Захиргаачын зардлын дүн ...%					
7 ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН					
ӨРТӨГ НӨХӨГДӨХГҮЙ ЗАРДАЛ					
...				
8 Өртөг нөхөгдөхгүй зардлын нийт дүн					
9 НИЙТ ДҮН					

[Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага]:

[Гэрээлэгч] компаниас:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Маят 5

"....." ХХК -ИЙН ТАЛБАЙН ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант ўе:

Тайланг жил тутам бэлтгэнэ.

4.2.1.												
	Дүн												
	Татан буулгалтын зардлын дүн												
Σ	Тухайн жилийн нийт дүн (1+2+3+4)												
5	Өмнөх оны төлөвлөгөө, төсөв дэх ажилд зарцуулсан дүн												
5.1.												
5.2.												
	Дүн												
Σ	Нийт дүн (1+2+3+4+5)												
6	Захиргааны зардлын дүн ...%												
Σ	ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН												
II													
....												
	Өртөг нөхөгдөхгүй зардлын нийт дүн												
Σ	НИЙТ ДҮН												
ӨРТӨГ НӨХӨГДӨХГҮЙ ЗАРДАЛ													

Тайлан гаргасан:

..... /
 (албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... /
 (албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /
 (албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 6**ЭСКРОУ ДАНСНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант үе:

Тайланг жил тутам бэлтгэнэ.

Дугаар	Огноо	Тайлант оны төлөвлөгөө, төсвийн дагуу				Ажлын гүйцэтгэлээр		Зөрүү
		Тооцох дүн	Тооцох хувь	Байршуулах хөрөнгө	Байршуулсан хөрөнгө	Тооцох дүн	Байршуулах хөрөнгө	
1	A	Б	В	Г=(Б*В)	Д	Е	Ж=(Е*В)	З=(Ж-Д)
2
3
4		(нийт дүн)	...	(нийт дүн)	(нийт дүн)	(нийт дүн)	(нийт дүн)	

Тайлан гаргасан:

..... //
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... //
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... //
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 7**ГАЗРЫН ТОСНЫ ХУВААЛТЫН ТАЙЛАН**

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант үе:

Тайланг сар тутам бэлтгэнэ.

Мөр/ Баганы дугаар	Үзүүлэлт	Тоо хэмжээ /баррель/			Мөнгөн дүн /ам.доллар/			
		Тайлант сар	Тайлант сарын өмнөх саруудын өссөн дун	Нийт өссөн дун	Тайлант сар	Тайлант сарын өмнөх саруудын өссөн дун	Тайлант жилийн нийт өссөн дун	
		A	B	В	Г	Д	Е	Ж
1	Борлуулсан газрын тосны хэмжээ							
2	(+/-) Хэмжилтийн залруулга							
3	Залруулга хийсэн газрын тос							
4	Газрын тосны нэгж үнэ							
5	Газрын тосны борлуулалтын орлого (3*4)							
6	Нөөц ашигласны төлбөр ...% (5*...%)							
7	Борлуулалтын зардал							
8	Үлдэх газрын тос (5-6-7)							
9	Өртөгт газрын тос	Нийт дун (8*...%)						
10	...%	Засгийн газар (9*....%)						
11		Гэрээлэгч (9*....%)						
12	Ашигт газрын тос	Нийт дун (8-9)						
13	...%	Засгийн газар (12*....%)						
14		Гэрээлэгч (12*....%)						
15	Засгийн газарт	Нөөц ашигласны төлбөр (=6)						
16	ногдох	Өртөгт газрын тос(=10)						
17	газрын тос	Ашигт газрын тос (=13)						
18		Нийт дун (15+16+17)						
19	Гэрээлэгчид ногдох	Өртөгт газрын тос (=11)						
20	газрын тос	Ашигт газрын тос (=14)						
21		Нийт дун (19+20)						
Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрийн мэдээлэл:								
22	Төлбөрийн үлдэгдэл /.....:/							
23	Тайлант хугацааны төлбөр:							
24	Төлөх дун /.....:/							

Тайлан гаргасан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Тайланг хүлээн авсан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маят 8

ГАЗРЫН ТОСНЫ НЭГЖ ҮНИЙН ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант ѿ:

Тайланг сар тутам бэлтгэнэ.

1. Сарын сүурь үнэ (бэнчмарк)

Д/д	Огноо	Сүурь үнэ (бэнчмарк)		
		Доод үнэ	Дээд үнэ	Дундаж үнэ
		А	Б	В
1	1			
2	2			
3	3			
4	4			
5	5			
6	6			
7	7			
8	8			
9	9			
10	10			
11	11			
12	12			
13	13			
14	14			
15	15			
16	16			
17	17			
18	18			
19	19			
20	20			
21	21			
22	22			
23	23			
24	24			
25	25			
26	26			
27	27			
28	28			
29	29			
30	30			
31	31			
32	32			
33	33			
34	34			
35	35			
36	36			
37	37			
38	38			
39	39			
40	40			
41	41			
42	42			
43	43			
44	44			
45	45			
46	46			
47	47			
48	48			
49	49			
50	50			
51	51			
52	52			
53	53			
54	54			
55	55			
56	56			
57	57			
58	58			
59	59			
60	60			
61	61			
62	62			
63	63			
64	64			
65	65			
66	66			
67	67			
68	68			
69	69			
70	70			
71	71			
72	72			
73	73			
74	74			
75	75			
76	76			
77	77			
78	78			
79	79			
80	80			
81	81			
82	82			
83	83			
84	84			
85	85			
86	86			
87	87			
88	88			
89	89			
90	90			
91	91			
92	92			
93	93			
94	94			
95	95			
96	96			
97	97			
98	98			
99	99			
100	100			
101	101			
102	102			
103	103			
104	104			
105	105			
106	106			
107	107			
108	108			
109	109			
110	110			
111	111			
112	112			
113	113			
114	114			
115	115			
116	116			
117	117			
118	118			
119	119			
120	120			
121	121			
122	122			
123	123			
124	124			
125	125			
126	126			
127	127			
128	128			
129	129			
130	130			
131	131			
132	132			
133	133			
134	134			
135	135			
136	136			
137	137			
138	138			
139	139			
140	140			
141	141			
142	142			
143	143			
144	144			
145	145			
146	146			
147	147			
148	148			
149	149			
150	150			
151	151			
152	152			
153	153			
154	154			
155	155			
156	156			
157	157			
158	158			
159	159			
160	160			
161	161			
162	162			
163	163			
164	164			
165	165			
166	166			
167	167			
168	168			
169	169			
170	170			
171	171			
172	172			
173	173			
174	174			
175	175			
176	176			
177	177			
178	178			
179	179			
180	180			
181	181			
182	182			
183	183			
184	184			
185	185			
186	186			
187	187			
188	188			
189	189			
190	190			
191	191			
192	192			
193	193			
194	194			
195	195			
196	196			
197	197			
198	198			
199	199			
200	200			
201	201			
202	202			
203	203			
204	204			
205	205			
206	206			
207	207			
208	208			
209	209			
210	210			
211	211			
212	212			
213	213			
214	214			
215	215			
216	216			
217	217			
218	218			
219	219			
220	220			
221	221			
222	222			
223	223			
224	224			
225	225			
226	226			
227	227			
228	228			
229	229			
230	230			
231	231			
232	232			
233	233			
234	234			
235	235			
236	236			
237	237			
238	238			
239	239			
240	240			
241	241			
242	242			
243	243			
244	244			
245	245			
246	246			
247	247			
248	248			
249	249			
250	250			
251	251			
252	252			
253	253			
254	254			
255	255			
256	256			
257	257			
258	258			
259	259			
260	260			
261	261			
262	262			
263	263			
264	264			
265	265			
266	266			
267	267			
268	268			
269	269			
270	270			
271	271			
272	272			
273	273			
274	274			
275	275			
276	276			
277	277			
278	278			
279	279			
280	280			
281	281			
282	282			
283	283			
284	284			
285	285			
286	286			
287	287			
288	288			
289	289			
290	290			
291	291			
292	292			
293	293			
294	294			
295	295			
296	296			
297	297			
298	298			
299	299			
300	300			
301	301			
302	302			
303	303			
304	304			
305	305			
306	306			
307	307			
308	308			
309	309			
310	310			
311	311			
312	312			
313	313			
314	314			
315	315			
316	316			
317	317			
318	318			
319	319			
320	320			
321	321			
322	322			
323	323			
324	324			
325	325			
326	326			
327	327			
328	328			
329	329			
330	330			
331	331			
332	332			
333	333			
334	334			
335	335			
336	336			
337	337			
338	338			
339	339			
340	340			
341	341			
342	342			
343	343			
344	344			
345	345			
346	346			
347	347			
348	348			
349	349			
350	350			
351	351			
352	352			
353	353			
354	354			
355	355			
356	356			
357	357			
358	358			
359	359			
360	360			
361	361			
362	362			
363	363			
364	364			
365	365			
366	366			
367	367			
368	368			
369	369			
370	370			
371	371			
372	372			
373	373			
374	374			
375	375			
376	376			
377	377			
378	378			

2. Сарын нэгжүнэ

Cap	Нэгжийн үнэ		
	Суурь үнийн дундаж (бэнчмарк)	Чанараас хамаарсан үнийн тохируулга	Газрын тосны нэгж үнэ
Д	E	Ж	З
.....-01			
.....-02			
.....
Жилийн дундаж үнэ			

Тайлан гаргасан:

(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Organo:

Маягт 9

БОРЛУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант ўе:

Тайланг сар тутам бэлтгэнэ.

Мөр/ Баганы дугаар	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Тайлант сарын нийт дүн	Тайлант сарын өмнөх саруудын өссөн дүн	Тайлант жилийн нийт өссөн дүн
	Зардал ангилал	Зардлын нэр төрөл / компанийн нэр						
	A	B	V	Г	Д	E	Ж	З
1	Тээврийн зардал	1. [Тээврийн компани -1]						
		2. [Тээврийн компани -2]						
							
		Нийт дүн						
2	Борлуулалтын бусад зардал	1. [Зардал -1]						
		2. [Зардал -2]						
							
		Нийт дүн						
3	Борлуулалтын нийт зардал						
4	Борлуулсан газрын тос							
5	Нэгж борлуулсан газрын тосонд ногдох дүн						

Тайлан гаргасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 10

БОРЛУУЛСАН ГАЗРЫН ТОСНЫ ХЭМЖИЛТИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант үе:

Тайланг сар тутам бэлтгэнэ.

1. Борлуулсан газрын тосны хэмжээ

Хуанлийн сар	Хүлээлгэн өгсөн цэг	Борлуулсан газрын тос	Tээвэрлэсэн шингэн	Тонныг баррелийн харьцаа
			баррель	
A	B	V	Г	Д
.....-01			
			
	Дүн			
.....-02			
			
	Дүн			
.....
Нийт дүн /өссөн/				

2. Тээвэрлэсэн шингэний хэмжээ (тухайн сарын задаргaa)

Тээврийн компани	Хүлээлгэн өгсөн цэг	Автомашин, вагон цистерний тоо	Tээвэрлэсэн хэмжээ
			тоо ширхэг
E	Ж	Z	I
[Тээврийн компани -1]		
		
	Дүн		
[Тээврийн компани -2]		
		
	Дүн		
.....
Нийт дүн /өссөн/			

Тайлан гаргасан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо:

Маягт 11

БОРЛУУЛСАН ГАЗРЫН ТОСНЫ ХЭМЖИЛТ, ЗАРДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Гэрээлэгчийн нэр:

Талбайн нэр:

Тайлант үе:

Тайланг сар тутам бэлтгэнэ.

Түхайн сарын тонн, баррелийн харьцаа (коэффициент)

Д/ д	Ачилтын мэдээ								Буулгалтын мэдээ								Тээврийн мэдээ				Борлуулалтын зарда						
	Хяналтын хуудасны дугаар	Шингэн		Нягт / API Gravity	Ус+МХ агууламж		Газрын тос		Ачсан огноо	Хүлээл гэн өгсэн огноо	Хүлээлгэн өгсэн цэг	Шингэн		Нягт / API Gravity	Ус+МХ агууламж	Газрын тос		Тээврийн компани	Тээвэрлэсэн хэмжээ		Тээврийн зардал	[Зардал-1]	[Зардал-2]	...			
		A	B		D	E	J	Z		I	K	L	M	N	O	Ө	P	R	S	T	U	V	Ф	Х	Ц	Ч	
...
Σ	Нийт дун	

Тайлан гаргасан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Хянасан:

..... / /
(албан тушаал) (гарын үсэг) (нэр)

Огноо:

Огноо: